

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тогтвортой амьжиргаа-3 төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/58/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Э.Энхбаатар Утас: 261740 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Грант Торнтон Аудит” ХХК Захирал: Б.Осоргарав Утас: 70110744 Цахим хаяг: info@mn.gt.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТОГТВОРТОЙ АМЬЖИРГАА
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ
Г.ЗОЛБОО ТАНАА

2024.03.25 № 07/829
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тогтвортой амьжиргаа-3 төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тогтвортой амьжиргаа-3 төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тогтвортой амьжиргаа-3 төслийн үйл ажиллагаа 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон ба харилцагч байгууллагуудын үлдэгдэл төлбөрийг хийх, Дэлхийн банкны үлдэгдэл санхүүжилтийг буцаан шилжүүлэх, санхүүжилтээс бусад орлогыг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх, тусгай дансыг хаах ажил гүйлгээнүүдийг дараагийн төсвийн жилд буюу 2024 онд хийж хаалтын санхүүгийн тайлангаа бэлтгэн гаргах төлөвлөгөөтэй байна.

Аудитын гол асуудал

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 330 сумын жилийн гүйцэтгэлийн үнэлгээг хөндлөнгийн 3 компани хийж гүйцэтгэсэн ба үр дүнд суурилсан "урамшуулал"-ыг тооцоолж 2023 оны төсвийн төсөлд тусгасны дагуу тайлант онд болзол хангасан, 65 хувиас дээш үнэлгээтэй 218 сумдад нийт 15,930,481.7 мянган төгрөгийн урамшууллыг Орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулан 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр олгосон байна. Сумдад олгох урамшууллыг тооцох суурь үнэлгээний дүнг Монгол улсын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан Орон нутгийн шилжүүлгийг тооцох аргачлалын дагуу Сангийн яам тооцож өгсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улс, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хоорондын 2014 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 5487 тоот 24,800.0 мянган ам.долларын санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хугацааг 2018 оны 12 дугаар сарын 31-нд дуусахаар байсан хэдий ч төслийн үндсэн зорилгын гүйцэтгэл нэмэлт санхүүжилтийн (SLP3) 6588 тоот санхүүжилтийн зээлээр 12,000.0 мянган ам доллар, Швейцарын хөгжлийн агентлагийн Итгэлцлийн сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 5,665.0 мянган ам.доллар нийт төслийн санхүүжилт 42,465.0 мянган ам.доллар болж өссөн бөгөөд төслийн хаалтын хугацааг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасан байна.

Тогтвортой амьжиргаа төсөл нь Дэлхийн банкнаас баталж гаргасан "Санхүүгийн удирдах гарын авлага"-д заасан нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланг Дэлхийн банканд хүргүүлдэг бол Төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар батлагдсан "Засгийн Газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, Засгийн Газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягтууд, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлал", УСНББОС 1-ийн дагуу аккруэл сууриар илэрхийлэн бэлтгэн хүргүүлдэг байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,330,990,647.27	657,578,626.31
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,330,990,647.27	657,578,626.31
311	Кассад байгаа бэлэн мөнгө	1,635,408.48	-
31110	Төгрөг	1,635,408.48	-
312	Банканд байгаа бэлэн мөнгө	4,329,355,238.79	657,578,626.31
31210	Төгрөг	933,187,658.18	111,970,547.01
31211	Төрийн санд байгаа бэлэн мөнгө	913,214,358.18	111,970,547.01
31213	Арилжааны банканд байгаа бэлэн мөнгө	19,973,300.00	-
3122	Гадаад валют	3,396,167,580.61	545,608,079.30
31223	Арилжааны банканд байгаа бэлэн мөнгө	3,396,167,580.61	545,608,079.30
33	АВЛАГА	-	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	284,183,230.16	235,597,676.31
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	284,183,230.16	235,597,676.31
39200	Биет хөрөнгө	284,183,230.16	235,597,676.31
39203	Авто – тээврийн хэрэгсэл	402,509,999.96	429,200,000.00
39203	Хуримтлагдсан элэгдэл	(164,460,555.53)	(224,576,666.70)
39205	Машин тоногтөхөөрөмж (компьютер)	237,097,235.46	237,097,235.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	(228,520,046.10)	(234,388,023.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	92,114,654.55	92,114,654.55
39208	Хуримтлагдсан элэгдэл	(54,558,058.18)	(63,849,523.64)
39300	Биет бус хөрөнгө	-	-
39301	Программ хангамж	6,300,000.00	6,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,300,000.00)	(6,300,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,615,173,877.43	893,176,302.62
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
41300	Өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,615,173,877.43	893,176,302.62
511	Засгийн газрын хувь оролцоо	4,615,173,877.43	893,176,302.62
512	Хуримтлагдсан үр дүн	4,615,173,877.43	893,176,302.62
51210	Өмнөх үеийн үр дүн	(32,335,877.93)	4,615,173,877.43
51220	Тайлант үеийн үр дүн	4,647,509,755.36	(3,721,997,574.81)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,615,173,877.43	893,176,302.62

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	13,423,245,999.96	17,462,947,000.00
12	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,183,036,000.00	17,462,947,000.00
122002	Тусламжийн санхүүжилт	-	-
141001	Зээлийн санхүүжилт	13,183,036,000.00	17,462,947,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	240,209,999.96	-
1200045	Үнэ төлбөргүй орлого	240,209,999.96	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,547,824,963.21	21,186,787,930.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,547,824,963.21	21,186,787,930.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,547,934,025.57	5,256,306,230.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	733,727,732.17	712,870,113.33
210101	Үндсэн цалин	733,727,732.17	712,870,113.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,296,248.30	75,831,409.79
210202	Нийгмийн даатгалын шимтгэл	90,296,248.30	75,831,409.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,800,000.00	34,200,000.00
210304	Байрны түрээс	37,800,000.00	34,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,875,454.39	5,562,932.90
210401	Бичиг хэрэг	368,727.27	378,090.90
210402	Тээвэр, шатахуун	2,546,536.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,810,585.85	5,184,842.00
210404	Ном хэвлэл	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	2,149,605.27	-
2107	Томилолт, зочны зардал	67,182,876.86	70,431,990.00
210702	Дотоод албан томилолт	67,182,876.86	70,431,990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	897,811,007.77	2,770,399,416.07
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	897,811,007.77	2,770,399,416.07
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	710,240,706.08	1,587,010,367.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	640,833,990.14	1,538,424,814.07
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,406,715.94	48,585,553.85
2131	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,999,890,937.64	15,930,481,700.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	6,999,890,937.64	15,930,481,700.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	3,875,421,036.75	(3,723,840,930.01)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	772,088,718.61	1,843,355.20
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	772,088,718.61	1,843,355.20
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	4,647,509,755.36	(3,721,997,574.81)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	(32,335,877.93)	(32,335,877.93)
Тайлант үеийн үр дүн	-	-	4,647,509,755.36	4,647,509,755.36
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	4,615,173,877.43	4,615,173,877.43
Тайлант үеийн үр дүн	-	-	(3,721,997,574.81)	(3,721,997,574.81)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	893,176,302.62	893,176,302.62

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	13,183,036,000.00	17,462,947,000.00
12	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,183,036,000.00	17,462,947,000.00
141001	Зээлийн санхүүжилт	13,183,036,000.00	17,462,947,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,785,445,537.99	21,138,202,376.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,785,445,537.99	21,138,202,376.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,785,554,600.35	5,207,720,676.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	733,727,732.17	712,870,113.33
210101	Үндсэн цалин	733,727,732.17	712,870,113.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,296,248.30	75,831,409.79
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	90,296,248.30	75,831,409.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,800,000.00	34,200,000.00
210304	Байрны түрээс	37,800,000.00	34,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,875,454.39	5,562,932.90
210401	Бичиг хэрэг	368,727.27	378,090.90
210402	Тээвэр, шатахуун	2,546,536.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,810,585.85	5,184,842.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	2,149,605.27	-
2107	Томилолт, зочны зардал	67,182,876.86	70,431,990.00
210702	Дотоод албан томилолт	67,182,876.86	70,431,990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,204,838,298.49	2,770,399,416.07
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,190,962,829.06	2,728,374,425.65
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	13,636,363.64	41,818,181.82
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	239,105.79	206,808.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	640,833,990.14	1,538,424,814.07
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	640,833,990.14	1,538,424,814.07
2131	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,999,890,937.64	15,930,481,700.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	6,999,890,937.64	15,930,481,700.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,397,590,462.01	(3,675,255,376.16)
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	772,088,718.61	1,843,355.20
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	772,088,718.61	1,843,355.20
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	772,088,718.61	1,843,355.20
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	4,169,679,180.62	(3,673,412,020.96)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	161,311,466.65	4,330,990,647.27
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,330,990,647.27	657,578,626.31

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,169,889,300.00	21,138,202,376.16	31,686,923.84	99.9
УРСГАЛ ЗАРДАЛ	21,169,889,300.00	21,138,202,376.16	31,686,923.84	99.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,239,407,600.00	5,207,720,676.16	31,686,923.84	99.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	716,500,000.00	712,870,113.33	3,629,886.67	99.5
Үндсэн цалин	716,500,000.00	712,870,113.33	3,629,886.67	99.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,000,000.00	75,831,409.79	20,168,590.21	79.0
Тэтгэврийн даатгал	96,000,000.00	75,831,409.79	20,168,590.21	79.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,200,000.00	34,200,000.00	-	100.0
Байрны түрээс	34,200,000.00	34,200,000.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	10,800,000.00	5,562,932.90	5,237,067.10	51.5
Бичиг хэрэг	3,600,000.00	378,090.90	3,221,909.10	10.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,200,000.00	5,184,842.00	2,015,158.00	72.0
Томилолт, зочны зардал	45,410,000.00	70,431,990.00	(25,021,990.00)	155.1
Дотоод албан томилолт	45,410,000.00	70,431,990.00	(25,021,990.00)	155.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,784,497,600.00	2,770,399,416.07	14,098,183.93	99.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,742,677,600.00	2,728,581,234.25	14,096,365.75	99.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	41,820,000.00	41,818,181.82	1,818.18	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,552,000,000.00	1,538,424,814.07	13,575,185.93	99.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,552,000,000.00	1,538,424,814.07	13,575,185.93	99.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,930,481,700.00	15,930,481,700.00	-	100.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	15,930,481,700.00	15,930,481,700.00	-	100.0
Засгийн газрын дотоод шилжүүлэг	15,930,481,700.00	15,930,481,700.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17,462,947,000.00	17,462,947,000.00	-	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	17,462,947,000.00	17,462,947,000.00	-	100.0
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	17,462,947,000.00	17,462,947,000.00	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,330,990,647.27	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	657,578,626.31	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт		1,843,355.20	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 764.7 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 764.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Төсөл хаагдахтай холбоотойгоор дээд шатны төсвийн захирагчийн анхааралд хандуулах дараах асуудлууд байна. Үүнд: -Төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн мэргэжилтэн нь санхүүгийн тайлангаа хуулийн цаглавар хугацаанд бэлтгэж аудитын байгууллагад хүргүүлээгүй; -Эрх бүхий байгууллагын шийдвэрээр 113,800.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй Nissan patrol маркийн тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлэн өгөх шийдвэр гарсан ч балансаас хасалтыг хийгээгүй; -Төслийн үйл ажиллагаа нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр бүрэн зогссон хэдий ч үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 315,400.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 2 тээврийн хэрэгслийг хүлээлгэн өгөх талаар эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй; Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 335,511.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил болон программ хангамжийг эрх бүхий байгууллагын тушаал шийдвэргүй СЯ-нд хүлээлгэн өгсөн, мөн хөрөнгө хүлээлцсэн акт үйлдээгүй байна	1	764,711.9			1	764,711.9						
Нийт дүн	1	764,711.9			1	764,711.9						

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.